

ГЛОБАЛЬ САНГИЙН ДЭМЖЛЭГТЭЙ ДОХ, СҮРЬЕЭГИЙН ТӨСЛИЙН ЖОЛООЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ УРИЛГА

Эрүүл мэндийн яам нь ДОХ, сүрьеэ, хумхаа өвчинтэй тэмцэх Глобаль сантай хамтран ажиллаж, ХДХВ, ДОХ, бэлгийн замаар дамжих халдвар, сүрьеэ өвчнөөс сэргийлэх, хянах чиглэлээр 2003-2023 онд 15 удаагийн төслийг үр дүнтэй хэрэгжүүлсэн. Глобаль сангийн дэмжлэгтэй 16 дахь удаагийн ДОХ, сүрьеэгийн төсөл нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байгаа бөгөөд Эрүүл мэндийн яам төслийн үндсэн хүлээн авагч байгууллагаар ажиллаж байна.

Эрүүл мэндийн яам тус ТӨСЛИЙН ЖОЛООЧ-ийн сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

Нэг. Ажлын байрны гүйцэтгэх чиг үүрэг:

Ажлын байрны зорилго: Төслийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн, аюулгүй явагдах нөхцөлөөр ханган, авто тээврийн хэрэгслийг байнгын бэлэн байдалд байлгах, хөтөлбөр зохицуулах нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад идэвх санаачилгатай ажиллах.

Ажлын байрны зорилт:

- i. Төслийн өдөр тутмын үйл ажиллагаа тасралтгүй, хэвийн явуулахад авто тээврийн хэрэгслээр үйлчлэх.
- ii. Замын хөдөлгөөнд оролцохдоо замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм, заавар, журмыг баримтлан осол авааргүй ажиллаж, ажилтнуудын амь нас, эрүүл мэнд, техникийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах.
- iii. Автомашины ашиглалтын болон шатахуун ашиглалтын тайланг сар бүр тооцооны нягтлан бодогчид өгөх.

Ажлын байрны цар хүрээ:

1. Төслийн үйл ажиллагаа, харилцагч, ажилтнуудтай холбогдох хувь хүний нууцыг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй, нууцыг чандлан хадгалж задруулахгүй байх;
2. Төслийн өдөр тутмын үйл ажиллагаа тасралтгүй, хэвийн явуулахад авто тээврийн хэрэгслээр үйлчлэх;
3. Гар утсаа байнга нээлттэй байлгаж /ажлын болон ажлын бус цагаар/, зайлшгүй шаардлагатай үед дуудсан цагт ирэх;
4. Хот болон орон нутгийн зам, маршрутыг судлах, осолгүй найдвартай зорчих үүднээс тухайн үеийн орчны болон цаг уурын нөхцөл байдалд тохируулан замын сонголтыг зөв хийх;
5. Автомашиндаа өдөр бүр хөнгөн цэвэрлэгээ, долоо хоног бүр их цэвэрлэгээ хийх
6. Гар утсаа байнга нээлттэй байлгаж /ажлын болон ажлын бус цагаар/, зайлшгүй шаардлагатай үед дуудсан цагт ирэх;
7. Замын хөдөлгөөнд оролцохдоо замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм, заавар, журмыг баримтлан техникийн бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллах;

8. Замын хөдөлгөөнд оролцохдоо машины бичиг баримт болон өөрийн жолооны үнэмлэхийг байнга авч явах;
9. Ажил үүрэг гүйцэтгэж явахдаа тээврийн хэрэгслийг зориулалтын зогсоол, талбай дээр аюулгүй байрлуулах, эзэнгүй болон түгжихгүй орхихгүй байх;
10. Автомашины техникийн бүрэн бүтэн байдлыг өглөө бүр шалгах, хариуцах.
11. Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний талаархи мэдээллийг тухай бүр цаг алдалгүй мэдээлж, эвдрэл гэмтлийг оношлох, доголдлыг тухай бүр засаж янзлах, зайлшгүй шаардлагатай тохиолдолд мэргэжлийн засварын газраар засвар үйлчилгээ хийлгэх;
12. Хөдөлгөөний аюулгүй байдлын талаар өндөр мэдлэгтэй байж, дүрмийн болон замын тэмдэг тэмдэглэгээний өөрчлөлтүүдийг тухай бүрд нь судлах, баримтлах;
13. Шатахууны хангалт, ашиглалтын нормыг мөрдөж ажиллах, шатахуун зарцуулалт нэмэгдсэн тохиолдолд шалтгааныг олж тогтоон арилгах арга хэмжээг шуурхай авах;
14. Шатахууны картыг тогтсон хугацаанд цэнэглэж, картыг хаяж үрэгдүүлэхгүй байх;
15. Шатахуун зарцуулалтын болон урсгал засвар үйлчилгээний тайланг сар бүр гаргаж тооцооны нягтлан бодогчид гаргаж өгөх;
16. Авто тээврийн хэрэгсэл ашиглалтын бүртгэлийг үнэн зөв хөтлөх, сар бүрийн тээврийн хэрэгсэл ашиглалтын тайланг тооцооны нягтлан бодогчид тайлагнах;
17. Жил бүрийн авто тээврийн хэрэгслийн оношилгоо, бүртгэл тооллогод цаг тухай бүрд хугацаа хэтрэлгүй орох.

Хоёр. Ажлын байрны шаардлага:

Ерөнхий шаардлага: Бүрэн дунд боловсролтой. В ангиллын жолооны эрхтэй.

Ажлын туршлага: Мэргэжлээрээ 5-аас дээш жил ажилласан байх.

Ур чадвар:

- Харилцааны өндөр соёлтой
- Хувийн зохион байгуулалт сайтай
- Хамт олонтой зохицон ажиллах чадвартай

Дараах материалыг бүрдүүлэн 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 17.30 цаг хүртэл Эрүүл мэндийн яамны бичиг хэргийн ажилтанд битүүмжилсэн байдлаар ирүүлнэ үү.

- 1.Төрийн албан хаагчийн анкет (Маягт №1);
2. Жолооны үнэмлэх, /мэргэшсэн үнэмлэх/
3. Тухайн албан тушаалд томилогдох хүсэлт (өөрийн мэдлэг, ур чадвараа илэрхийлсэн байх);
4. Иргэний үнэмлэхийн хуулбар;
5. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа
6. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт/*e-mongolia*–*c татан авах*/.

7. Тухайн ажлын байрны чиг үүрэгтэй холбогдуулан ажлын туршлага болон бусад тусгай шаардлагыг нотлох баримт бичиг, өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолтын хамт ирүүлнэ үү.

Хаяг: Эрүүл мэндийн яам, Засгийн газрын VIII байр, Олимпын гудамж-2, Сүхбаатар дүүрэг 14210, Улаанбаатар хот.

Холбогдох утас: 51-261629, 70008010.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ